- 38.2. Захиалагч гэрээ байгуулах эрх олгосон бол энэ тухай шийдвэр, мэдэгдэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг холбогдох журмын дагуу ил болгох тухай ТШЗ-ны 38.1.2, 38.1.3-т заасан мэдэгдэлд дурдана.
- 38.3. Захиалагч бүх тендерээс татгалзсан бол хуулийн 30.4-т заасан дахин нээлттэй, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах, эсхүл гэрээ шууд байгуулах тухай шийдвэрийг ТШЗ-ны 38.1.3-т заасан мэдэгдэлд дурдана.¹

39. Гэрээ байгуулах эрх олгох

- 39.1. Захиалагч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг ТШЗ-ны 38.1.1-д заасан мэдэгдлээр олгоно. Хэрэв “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсэн бол уг

¹ Гэрээ шууд байгуулах аргаар тендер шалгаруулалт зохион байгуулах үед энэ заалт хамаарахгүй.

үнийг гэрээний үнээр тогтоож, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заана.

39.2. Дараах тохиолдолд хуулийн 20.7.2-т заасан нөхцөл үүссэн гэж үзэж тендерийн баталгааг улсын орлого болгоно:

39.2.1. гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд дурдсан гэрээний үнийг хүлээн зөвшөөрөөгүй;

39.2.2. ТШЗ-ны 40 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй (хэрэв гүйцэтгэлийн баталгаа шаардсан бол);

39.2.3. ТШЗ-ны 41 дүгээр зүйлд заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй.

39.3. ТШЗ-ны 39.2-т заасан нөхцөл байдал үүсвэл удаах хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж гэрээ байгуулах эрх олгоно.

40. Гүйцэтгэлийн баталгаа

40.1. ТӨХ-д заасан бол шалгарсан тендерт оролцогч нь гэрээний үнийн 5 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг ТШЗ-ны 8.5-д заасан гэрээний нөхцөлийн хавсралт маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

40.2. Гүйцэтгэлийн баталгаа нь ТШЗ-ны 23.3-т заасан хэлбэрээр байж болох ба гадаадын этгээдээс гаргуулах бол ТШЗ-ны 23.4-т заасан шаардлагыг хангасан байна.

40.3. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.

41. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах

41.1. Захиалагч ТШЗ-ны 8.5-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, шалгарсан тендерт оролцогчид хүргүүлнэ.

41.2. Шалгарсан тендерт оролцогч ТШЗ-ны 41.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ. Захиалагчийн тогтоох энэ хугацаа нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтсан байна.

41.3. Шалгарсан тендерт оролцогч ТШЗ-ны 41.2-т заасан хугацааны дотор гэрээг зохих ёсоор баталгаажуулж, гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн бол захиалагч гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах үүрэгтэй.

41.4. ТШЗ-ны 41.3-т заасан захиалагчийн үүрэг нь төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад эрх бүхий этгээд, эсхүл шүүхээс гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хуульд

зааснаар хүчингүй болгосон, эсхүл хэрэгжилтийг түдгэлзүүлсэн тохиолдолд хамаарахгүй.

Ё. БУСАД

42. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол

42.1. Тендерт оролцогч тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хууль тогтоомжийн дагуу гаргана.

43. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалт

43.1. ТШЗ-ны 1.1-д заасан тендер шалгаруулалтыг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж байгаа үед энэ тухай ТӨХ болон тендерийн урилгад заана.

43.2. Захиалагч ТШЗ-ны 43.1-д заасны дагуу зохион байгуулах тендер шалгаруулалтад энэ тендерийн баримт бичгээс гадна “Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам”-д заасан нөхцөлийг мөрдөнө.

43.3. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалтаар худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр бүрэн батлагдах хүртэл гэрээ байгуулахгүй.

43.4. Худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй, эсхүл цар хүрээ, хүчин чадлыг өөрчилж, төсөвт өртгийг ТШЗ-ны 2.1-т зааснаас өөрөөр баталсан бол урьдчилсан худалдан авах ажиллагааг хэрэгжих боломжгүй болсон гэж үзэж гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгоно.

43.5. ТШЗ-ны 43.4-т зааснаар гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгосонтой холбоотой аливаа эрсдэлийг тендерт оролцогч хариуцна.

44. Тендер шалгаруулалтын мэдээллийг нийтлэх

44.1. Тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу цахим системээр ил болгоно.

44.2. Захиалагч нээлтийн тэмдэглэл, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд олон нийтэд ил тод мэдээлнэ.

II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Санамж

Захиалагч худалдан авах барааны онцлог шинж, тендерт оролцогчид тавигдах холбогдох хууль тогтоомж, түүний зарчимд нийцсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгана.

Тендерийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулахад дараах зүйлийг анхаарна. Үүнд:

1. ТӨХ нь ТШЗ-ны зүйл, заалт болон түүнд хамаарах хэсгийг налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг нөхөх, гүйцээх зорилготой ба ТӨХ-д мөр нэмэхгүй, хасахгүй байх;
2. Тендерт оролцогчийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагад тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буйг тогтоох зорилгоор шаардах баримт бичиг нь зөвхөн тендерт оролцогчийг тухайн бараа нийлүүлэх гэрээний үүргийг гүйцэтгэх чадавх, туршлагатай болохыг нотлох баримт бичиг байна;
3. ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан баримт бичгүүдээс аль тохирох баримт бичгийг сонгож ТӨХ-д тусгайлан заана;
4. Тендерт оролцогч өөрийн тендерийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. Иймд захиалагч хуулиар шаардсанаас бусад тохиолдолд тендерт хавсарган ирүүлэх баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх, орчуулагчийн тэмдгээр баталгаажуулахыг тендерт оролцогчоос шаардахгүй;
5. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбогдсон бусад мэдээллийн сангаас илгээсэн өгөгдлийг нотлох баримт бичгийг тендерт ирүүлэхийг шаардахгүй байх. Тухайлбал, Монгол Улсын хуулийн этгээдэд хамаарах улсын бүртгэлийн гэрчилгээ, тендерийн баталгаа, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт гэх мэт болно.

Энэхүү санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Эм, эмнэлгийн хэрэгсэл, өндөр өртөгт хэрэгсэл худалдан авах
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: ТТАХНЭ/202212006/01
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Нийт 69 багц
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: БАГЦ 2. МЭДЭЭГҮЙЖҮҮЛЭХ БА БУЛЧИН СУЛРУУЛАХ, ХАР ТАМХИНЫ БЭЛДМЭЛҮҮД /Дотоодын үйлдвэрлэгч/ БАГЦ 4. ӨВЧИН НАМДААХ, ХАЛУУН БУУРУУЛАХ, ҮРЭВСЛИЙН ЭСРЭГ ЭМҮҮД /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/ БАГЦ 7. НЯНГИЙН ЭСРЭГ БЭЛДМЭЛҮҮД /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/ БАГЦ 9. ХАЛДВАРЫН БОЛОН НЯНГИЙН ЭСРЭГ БУСАД БОДИС дотоодын үйлдвэрлэл/ БАГЦ 10. ХАЛДВАРЫН БОЛОН НЯНГИЙН ЭСРЭГ БУСАД БОДИС дотоодын үйлдвэрлэл/ БАГЦ 15. ЭЛЕКТРОЛИТИЙН СОЛИЛЦООНД НӨЛӨӨЛӨХ БЭЛДМЭЛҮҮД /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/ БАГЦ 18. АМИН ДЭМ, ЭРДЭС БОДИС, ДАРХЛАА ДЭМЖИХ /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/ БАГЦ 27. УЛАМЖЛАЛТ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАН /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгө

ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 5,324,234,600 төгрөг	
	Багц	Төсөв
	БАГЦ 1. МЭДЭЭГҮЙЖҮҮЛЭХ БА БУЛЧИН СУЛРУУЛАХ, ХАР ТАМХИНЫ БЭЛДМЭЛҮҮД /Импортын/	47,036,300
	БАГЦ 2. МЭДЭЭГҮЙЖҮҮЛЭХ БА БУЛЧИН СУЛРУУЛАХ, ХАР ТАМХИНЫ БЭЛДМЭЛҮҮД /Дотоодын үйлдвэрлэгч/	56,329,500
	БАГЦ 3. ӨВЧИН НАМДААХ, ХАЛУУН БУУРУУЛАХ, ҮРЭВСЛИЙН ЭСРЭГ ЭМҮҮД	33,895,800
	БАГЦ 4. ӨВЧИН НАМДААХ, ХАЛУУН БУУРУУЛАХ, ҮРЭВСЛИЙН ЭСРЭГ ЭМҮҮД /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/	10,029,000
	БАГЦ 5. СЭТГЭЦ НӨЛӨӨТ БОЛОН УНАЛТ ТАТАЛТЫН ЭСРЭГ ЭМҮҮД	74,987,000
	БАГЦ 6. НЯНГИЙН ЭСРЭГ БЭЛДМЭЛҮҮД	90,485,710
	БАГЦ 7. НЯНГИЙН ЭСРЭГ БЭЛДМЭЛҮҮД /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/	5,922,400
	БАГЦ 8. ХАЛДВАРЫН БОЛОН НЯНГИЙН ЭСРЭГ БУСАД БОДИС	65,622,340
	БАГЦ 9 ХАЛДВАРЫН БОЛОН НЯНГИЙН ЭСРЭГ БУСАД БОДИС дотоодын үйлдвэрлэл/	9,805,000
	БАГЦ 10 ХАЛДВАРЫН БОЛОН НЯНГИЙН ЭСРЭГ БУСАД БОДИС дотоодын үйлдвэрлэл/	16,000,000
	БАГЦ 11. АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БОДИС , ХЭРЭГСЭЛ	213,370,000
	БАГЦ 12. СИЙВЭН ОРЛОХ СУДСААР ӨГӨХ ТЭЖЭЭЛҮҮД БОЛОН ЦУСНЫ УРСГАЛД НӨЛӨӨЛӨХ ЭМҮҮД	62,121,100
	БАГЦ 13. ЗСС-НЫ БОЛОН ДАРАЛТ БУУРУУЛАХ ЭМҮҮД	38,773,400
	БАГЦ 14. ХБЗ-ЫН БОЛОН ДААВАР ДОТООД ШҮҮРЛИЙН ЭМҮҮД	93,228,450
	БАГЦ 15. ЭЛЕКТРОЛИТИЙН СОЛИЛЦООНД НӨЛӨӨЛӨХ БЭЛДМЭЛҮҮД /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/	37,948,500
	БАГЦ 16. НҮД ЧИХ ХАМАР ХООЛОЙН ӨВЧИНД ХЭРЭГЛЭХ ЭМҮҮД	4,900,000
	БАГЦ 17. АМЬСГАЛЫН ЗАМ,АРЬСНЫ ӨВЧНИЙГ ЭМЧЛЭХ ЭМҮҮД	16,372,300
	БАГЦ 18. АМИН ДЭМ, ЭРДЭС БОДИС, ДАРХЛАА ДЭМЖИХ /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/	52,262,000
	БАГЦ 19. АМИН ДЭМ, ЭРДЭС БОДИС, ДАРХЛАА ДЭМЖИХ	24,519,400
	БАГЦ 20. ТАРИУР	76,770,000
	БАГЦ 21. ДҮРС ОНОШЛОГООНЫ ХАЛЬС, РЕНТГЕНИЙ ХОР	83,460,000
	БАГЦ 22. ОРООХ БООХ МАТЕРИАЛ /импорт/	54,549,400
БАГЦ 23.ХАМГААЛАХ ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ	86,950,000	

БАГЦ 24. МЭС ЗАСЛЫН УТАСНУУД	69,458,552
БАГЦ 25. МЭС ЗАСЛЫН НЭГ УДААГИЙН ТУСЛАХ ХЭРЭГСЛҮҮД	84,123,000
БАГЦ 26. ЭМНЭЛГИЙН РЕЗИН БА ЖИЖИГ ХЭРЭГСЭЛ	136,348,000
БАГЦ 27. УЛАМЖЛАЛТ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАН /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/	13,112,500
БАГЦ 28. ШҮД ЭМЧИЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ ХЭРЭГСЛҮҮД	35,535,500
БАГЦ 29. ХИЙМЭЛ ШҮДНИЙ МАТЕРИАЛ ХЭРЭГСЛҮҮД	10,850,000
БАГЦ 30. ГЕМАТЛОГИЙН УРВАЛЖ	18,500,000
БАГЦ 31. ГЕМАТЛОГИЙН УРВАЛЖ	51,493,000
БАГЦ 32. ЦУСНЫ БҮЛЭГНЭЛТ ТОДОРХОЙЛОХ УРВАЛЖУУД	86,180,880
БАГЦ 33. БИОХИМИЙН УРВАЛЖУУД	102,299,350
БАГЦ 34. ТҮРГЭВЧИЛСЭН ОНОШЛУУР БА ЦУСНЫ БҮЛЭГ ТОДОРХОЙЛОХ УУСМАЛУУД	33,400,500
БАГЦ 35. ШЭЭСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ УУСМАЛ	39,711,000
БАГЦ 36. ШЭЭСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ УУСМАЛ	10,841,000
БАГЦ 37. БАКТЕРИОЛОГИЙН УРВАЛЖУУД	26,815,000
Багц 38. ЛАБОРАТОРИЙН НЭГ УДААГИЙН ХЭРЭГСЛҮҮД	29,101,850
БАГЦ 39. ЛАБОРАТОРИЙН ШИЛЭН ЭДЛЭЛҮҮД	2,631,120
БАГЦ 40. ИММУНОЛОГИЙН УРВАЛЖ	255,127,200
БАГЦ 41. ЦУС ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮН	13,553,000
БАГЦ-42. ХҮЧИЛТӨРӨГЧ БУСАД ХИЙ	38,140,000
БАГЦ 43. ХАРШЛЫН СОРИЛ	4,300,000
БАГЦ 44.ЭМЧИЛГЭЭ, ОНОШЛОГООНЫ АППАРАТЫН ДАГАЛДАХ НЭГ УДААГИЙН ХЭРЭГСЛҮҮД	29,460,000
БАГЦ 45. ГЕМОДИАЛИЗ ЭМЧИЛГЭЭНИЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ	386,377,000
БАГЦ 46. РЕНТГЕН ЗУРГИЙН ХЭРЭГСЭЛ	15,325,000
БАГЦ 47. ПАРЭНТЕРАЛ ТЭЖЭЭЛИЙН ЦОГЦ БҮРДЭЛ	38,662,000
БАГЦ 48. БИОХИМИЙН УРВАЛЖУУД	133,678,453
БАГЦ 49. МОЛЕКУЛ БИОЛОГИЙН УРВАЛЖ /ДНХ ТЕХНИОЛОГИ/	130,720,000
БАГЦ 50. ГИСТОЛОГИЙН БУДАГ, УРВАЛЖУУД	29,550,000
БАГЦ 51. УЛААН ЭСИЙН ТУНАХ ХУРД ТОДОРХОЙЛОХ ШИНЖИЛГЭЭНИЙ ДОТООД ХЯНАЛТЫН УУСМАЛ	4,800,000

	БАГЦ 52. ЕРОС ГАЗ АНАЛИЗАТОРЫН УРВАЛЖУУД	23,130,400
	БАГЦ 53 . МИКРО ЭЛЕМЕНТИЙН ҮЗЭХ ОНОШЛУУР	5,051,000
	БАГЦ 54. ХЕЛИКО БАКТЕРИЙН ОНОШЛУУР	30,000,000
	БАГЦ- 55 ЭМИЙН НЭГЖ ТУНГИЙН САВЛАГААНЫ МАТЕРИАЛ	11,828,000
	Багц 56. ЕРӨНХИЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАЛТ	348,521,575
	БАГЦ 57. ЕРӨНХИЙ МЭС ЗАСЛЫН ХЭРЭГСЭЛ	474,520,020
	БАГЦ 58. БӨӨРНИЙ МЭС ЗАСАЛ	43,490,000
	БАГЦ 59. МЭС ЗАСЛЫН НЭГ УДААГИЙН ХЭРЭГСЭЛ	224,009,100
	БАГЦ 60. ЭРҮҮ НҮҮРНИЙ МЭС ЗАСАЛ	24,742,500
	БАГЦ 61. УХАРХАЙН ХАНА НӨХӨН СЭРГЭЭХ МЭС ЗАСАЛ	18,772,500
	БАГЦ 62. УЯН ДУРАНГИЙН ХЭРЭГСЭЛ	34,175,000
	БАГЦ 63. ТАРХИНЫ МЭС ЗАСАЛ	38,700,000
	БАГЦ 64. НУРУУНЫ МЭС ЗАСАЛ	365,300,000
	БАГЦ 65. ШӨРМӨС ХОЛБООСЫН ГЭМТЛИЙН МЭС ЗАСАЛ	294,303,000
	БАГЦ 66 ДЭЭД МӨЧНИЙ ЯСНЫ ХУГАРЛЫН МЭС ЗАСАЛ	36,490,000
	БАГЦ 67. ДООД МӨЧНИЙ ХУГАРАЛ	21,610,000
	БАГЦ 68. ТОМ ҮЕНИЙ ГЭМТЭЛ, ЭМГЭГИЙН МЭС ЗАСАЛ (ӨВДӨГ ҮЕНИЙ ХЭРЭГСЭЛ)	166,480,000
	БАГЦ 69. ТОМ ҮЕНИЙ ГЭМТЭЛ, ЭМГЭГИЙН МЭС ЗАСАЛ (ТҮНХНИЙ ҮЕНИЙ ХЭРЭГСЭЛ)	77,680,000
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА		
ТШЗ 9.2	<p>Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:</p> <p>Хүлээн авагчийн нэр: Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг А блок 6 давхар Захиргааны хэсэг 617 тоот</p> <p>Утасны дугаар: 51-262301</p> <p>Цахим шуудангийн хаяг: ttakhne.tender2021@gmail.com</p>	
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”	

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 13.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”
ТШЗ 16.1	Хувилбарт санал ирүүлэхийг “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 18.2	Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: - Борлуулалтын орлогын хэмжээ: ТШЗ-ны 18.3-т заасан хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн 50 хувиас багагүй байх. Батлагдсан төсөв гэдэг нь оролцож буй багцуудын батлагдсан төсвийн нийлбэр байна.
ТШЗ 18.2.5	Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ санал болгож буй үнийн дүнгийн 50% болон түүнээс их байх
ТШЗ 18.3	Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2020 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, 2021 оны санхүүгийн тайлан
ТШЗ 18.6	Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: Ижил төстэй гэрээний туршлага: Сүүлийн 2 жил /2020, 2021/ Уг хугацаанд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ доод тал нь 2 удаа. Батлагдсан төсөв гэдэг нь оролцож буй багцуудын батлагдсан төсвийн нийлбэр байна.
ТШЗ 18.6.1	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана” - Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн оношлуур урвалж хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүн, вакцин, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох, ханган нийлүүлэх
ТШЗ 18.6.3	Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл: Шаардана. Мэргэжлийн диплом, үнэмлэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ бүхий ажилтаны овог нэр, РД, албан тушаалын жагсаалтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн “Лавлагаа” хэсгээс шалгахыг зөвшөөрсөн тухай мэдэгдэлийн хамт ирүүлэх. /НД төлөлт болон Мэргэжлийн дипломыг шалгана/
ТШЗ 18.6.4	Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: “Шаардлагатай” - Гэрээ дүгнэсэн акт ирүүлэх.

	- <i>Хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй гэрээний жагсаалтыг баталгаажуулж ирүүлэх.</i>
ТШЗ 18.6.7	Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: <i>Шаардана. Барааг стандартын дагуу тээвэрлэн нийлүүлэх автомашин, тоног төхөөрөмжийн мэдээллийг ирүүлэх.</i>
ТШЗ 18.6.8	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерийн баримт бичигт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ. 2. Тендерт оролцогчыг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг ирүүлнэ. 3. Оролцогч нь харъяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэсээс 2021 оны 12 сарын 31-ний байдлаар өр төлбөртэй эсэх талаарх тодорхойлолт ирүүлнэ. 4. 2021 оны нийгмийн даатгалын тайланг НД7, НД8 маягтын дагуу ирүүлнэ. Сүүийн 3 сарын мэдээллийг цахим системээс шалгахыг зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. 5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн төрөлжсөн архивын “сүүлийн 3 жилд иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан эсэх” талаарх тодорхойлолт ирүүлнэ. 6. Бараа бүтээгдэхүүн үндсэн савалгаан дээрх шошго сандартын шаардлага хангасан байна. 7. Эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх улс, үйлдвэрлэгчийг тодорхой зааж баталгааг ирүүлнэ. 8. Барааны техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан нотлох баримт, Монгол хэл дээр ирүүлнэ. /Орчуулгын үнэн магадтайг тендерт оролцогч бүрэн хариуцна/ 9. Эм, эмнэлгийн хэрэгслийн үндсэн савлагаан дээрх шошго GMP болон MNS5524:2014 стандартын шаардлагыг хангасан байна. 10. Эмнэлгийн хэрэгслийн хувьд загвар дээжийг бараа тус бүрт ирүүлнэ. 11. Тендерт оролцогч нь үйлдвэрлэгчийн орны зохицуулагч эрх бүхий этгээдээс эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх эрхийг баталгаажуулсан гэрчилгээг хавсаргасан байна /үүнд: албан ёсны дистрибьютерийн эрх, түншлэлийн гэрээ, импортын гэрээг/ Монгол хэлээр орчуулсан байна. 12. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу ирүүлнэ. 13. Олон улсын чанарын ISO, CE болон MNS, YФӨ зэрэг стандартыг хангасан эсэхийг гэрчлэх гэрчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх улс, үйлдвэрлэгчийг тодорхой заана. 14. Лабораторын урвалжуудын багцууд дээр одоо ашиглагдаж буй аппаратууды тодотгон өгсөн бөгөөд шинээр аппарат санал болгосон тохиолдолд тендерт шалгарсан компани нь гэрээний хугацаанд програм хангамж болоод техникийн холболт зэргийг бүрэн хариуцна. 15. Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлэх тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлтэй бол давуу эрх бараа жагсаалт, хүсэлтэй албан бичгээр баталгаажуулан ирүүлнэ.

ТШЗ 18.7.	Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардахгүй”
ТШЗ 19.5.	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх хугацаа: Нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэмт хийх.
ТШЗ 20.5.	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 20.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “Тийм” Incoterms 2020, DDP, ТТАХНЭ-ийн клиник эмзүйн албаны эмийн нөөцийн өрөө
ТШЗ 23.1	Тендерийн баталгаа: “Шаардана” Тендерийн баталгаа шаардах бол тендерийн баталгааны дүн төсөвт өртгийн 1 хувиар тооцож Байршуулна.
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 24.5.3	ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: 1. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл; 2. Харилцагч банкнаас хугацаа хэтэлсэн хүүгийн өр төлбөргүй талаарх тодорхойлолт.
ТШЗ 25.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2022 оны 02 дугаар 21-ний өдөр Цаг: 10 цаг 00 минут
ТШЗ 27.1.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Цаг: 10 цаг 30 минут Тендер нээх газрын хаяг: Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 4-р хороо Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг А блок 8 давхар хурлын танхим.
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.2	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: “Ашиглана” Эм, эмнэлгийн хэрэгсэлийн үнэлгээний арга.
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 40.1	Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Тийм” ТШЗ-ны 8.5-т заасан гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.

Ё. БУСАД

ТШЗ 43.1

Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: Үгүй

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.*
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.*
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.*
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.*
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.*
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.*

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч тендерт оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд тендерт оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан тендерт оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр:

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1			
2			
3			
...			

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]

Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	ТӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Захиалагч бараа хүлээн авах хугацаа	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа
					(эхлэх болон дуусах хугацаа)	(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	[Барааны нэрийг бичих]	[нээжийн тоо ширхгийг бичих]	[Хэмжих нээжийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ байгуулснаас хойш нийлүүлэх хугацаа бич. Жишээ нь: 2020.10.01-ээс 2020.10.14]	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]
2	БАГЦ 1. МЭДЭЭГҮЙЖҮҮЛЭХ БА БУЛЧИН СУЛРУУЛАХ, ХАР ТАМХИНЫ БЭЛДМЭЛҮҮД /Импортын/		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
3	БАГЦ 2. МЭДЭЭГҮЙЖҮҮЛЭХ БА БУЛЧИН СУЛРУУЛАХ, ХАР ТАМХИНЫ БЭЛДМЭЛҮҮД /Дотоодын үйлдвэрлэгч/		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 //Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
4	БАГЦ 3. ӨВЧИН НАМДААХ, ХАЛУУН БУУРУУЛАХ, ҮРЭВСЛИЙН ЭСРЭГ ЭМҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 //Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
5	БАГЦ 4. ӨВЧИН НАМДААХ, ХАЛУУН БУУРУУЛАХ, ҮРЭВСЛИЙН ЭСРЭГ ЭМҮҮД /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	

6	БАГЦ 5. СЭТГЭЦ НӨЛӨӨТ БОЛОН УНАЛТ ТАТАЛТЫН ЭСРЭГ ЭМҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
7	БАГЦ 6. НЯНГИЙН ЭСРЭГ БЭЛДМЭЛҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
8	БАГЦ 7. НЯНГИЙН ЭСРЭГ БЭЛДМЭЛҮҮД /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
9	БАГЦ 8. ХАЛДВАРЫН БОЛОН НЯНГИЙН ЭСРЭГ БУСАД БОДИС		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
10	БАГЦ 9 ХАЛДВАРЫН БОЛОН НЯНГИЙН ЭСРЭГ БУСАД БОДИС дотоодын үйлдвэрлэл/		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
11	БАГЦ 10 ХАЛДВАРЫН БОЛОН НЯНГИЙН ЭСРЭГ БУСАД БОДИС дотоодын үйлдвэрлэл/		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
12	БАГЦ 11. АРИУТГАЛ ХАЛДВАРГУЙТГЭЛИЙН БОДИС , ХЭРЭГСЭЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
13	БАГЦ 12. СИЙВЭН ОРЛОХ СУДСААР ӨГӨХ ТЭЖЭЭЛҮҮД БОЛОН ЦУСНЫ УРСГАЛД НӨЛӨӨЛӨХ ЭМҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
14	БАГЦ 13. ЗСС-НЫ БОЛОН ДАРАЛТ БУУРУУЛАХ ЭМҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	

15	БАГЦ 14. ХБЗ-ЫН БОЛОН ДААВАР ДОТООД ШҮҮРЛИЙН ЭМҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
16	БАГЦ 15. ЭЛЕКТРОЛИТИЙН СОЛИЛЦООНД НӨЛӨӨЛӨХ БЭЛДМЭЛҮҮД /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
17	БАГЦ 16. НҮД ЧИХ ХАМАР ХООЛОЙН ӨВЧИНД ХЭРЭГЛЭХ ЭМҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
18	БАГЦ 17. АМЬСГАЛЫН ЗАМ,АРЬСНЫ ӨВЧНИЙГ ЭМЧЛЭХ ЭМҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
19	БАГЦ 18. АМИН ДЭМ, ЭРДЭС БОДИС, ДАРХЛАА ДЭМЖИХ /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
20	БАГЦ 19. АМИН ДЭМ, ЭРДЭС БОДИС, ДАРХЛАА ДЭМЖИХ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
21	БАГЦ 20. ТАРИУР		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
22	БАГЦ 21. ДҮРС ОНОШЛОГООНЫ ХАЛЬС, РЕНТГЕНИЙ ХОР		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
23	БАГЦ 22. ОРООХ БООХ МАТЕРИАЛ /импорт/		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
24	БАГЦ 23.ХАМГААЛАХ ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25	

					/Эмнэлгийн хэрэгцээг хангана/ 2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
25	БАГЦ 24. МЭС ЗАСЛЫН УТАСНУУД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
26	БАГЦ 25. МЭС ЗАСЛЫН НЭГ УДААГИЙН ТУСЛАХ ХЭРЭГСЛҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
27	БАГЦ 26. ЭМНЭЛГИЙН РЕЗИН БА ЖИЖИГ ХЭРЭГСЭЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
28	БАГЦ 27. УЛАМЖЛАЛТ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАН /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧ/		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
29	БАГЦ 28. ШҮД ЭМЧИЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ ХЭРЭГСЛҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
30	БАГЦ 29. ХИЙМЭЛ ШҮДНИЙ МАТЕРИАЛ ХЭРЭГСЛҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
31	БАГЦ 30. ГЕМАТЛОГИЙН УРВАЛЖ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
32	БАГЦ 31. ГЕМАТЛОГИЙН УРВАЛЖ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
33	БАГЦ 32. ЦУСНЫ БҮЛЭГНЭЛТ ТОДОРХОЙЛОХ УРВАЛЖУУД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	

34	БАГЦ 33. БИОХИМИЙН УРВАЛЖУУД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
35	БАГЦ 34. ТҮРГЭВЧИЛСЭН ОНОШЛУУР БА ЦУСНЫ БҮЛЭГ ТОДОРХОЙЛОХ УУСМАЛУУД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
36	БАГЦ 35. ШЭЭСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ УУСМАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
37	БАГЦ 36. ШЭЭСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ УУСМАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
38	БАГЦ 37. БАКТЕРИОЛОГИЙН УРВАЛЖУУД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
39	Багц 38. ЛАБОРАТОРИЙН НЭГ УДААГИЙН ХЭРЭГСЛҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
40	БАГЦ 39. ЛАБОРАТОРИЙН ШИЛЭН ЭДЛЭЛҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
41	БАГЦ 40. ИММУНОЛОГИЙН УРВАЛЖ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
42	БАГЦ 41. ЦУС ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮН		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
43	БАГЦ-42. ХҮЧИЛТӨРӨГЧ БУСАД ХИЙ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25	

					/Эмнэлгийн хэрэгцээг хангана/ 2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
44	БАГЦ 43. ХАРШЛЫН СОРИЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
45	БАГЦ 44.ЭМЧИЛГЭЭ, ОНОШЛОГООНЫ АППАРАТЫН ДАГАЛДАХ НЭГ УДААГИЙН ХЭРЭГСЛҮҮД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
46	БАГЦ 45. ГЕМОДИАЛИЗ ЭМЧИЛГЭЭНИЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
47	БАГЦ 46. РЕНТГЕН ЗУРГИЙН ХЭРЭГСЭЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
48	БАГЦ 47. ПАРЭНТЕРАЛ ТЭЖЭЭЛИЙН ЦОГЦ БҮРДЭЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
49	БАГЦ 48. БИОХИМИЙН УРВАЛЖУУД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
50	БАГЦ 49. МОЛЕКУЛ БИОЛОГИЙН УРВАЛЖ /ДНХ ТЕХНИОЛОГИ/		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
51	БАГЦ 50. ГИСТОЛОГИЙН БУДАГ, УРВАЛЖУУД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
52	БАГЦ 51. УЛААН ЭСИЙН ТУНАХ ХҮРД ТОДОРХОЙЛОХ ШИНЖИЛГЭЭНИЙ ДОТООД ХЯНАЛТЫН УУСМАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	

53	БАГЦ 52. EPOS ГАЗ АНАЛИЗАТОРЫН УРВАЛЖУУД		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
54	БАГЦ 53 . МИКРО ЭЛЕМЕНТИЙН ҮЗЭХ ОНОШЛУУР		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
55	БАГЦ 54. ХЕЛИКО БАКТЕРИЙН ОНОШЛУУР		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
56	БАГЦ- 55 ЭМИЙН НЭГЖ ТУНГИЙН САВЛАГААНЫ МАТЕРИАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
57	Багц 56. ЕРӨНХИЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАЛТ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
58	БАГЦ 57. ЕРӨНХИЙ МЭС ЗАСЛЫН ХЭРЭГСЭЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
59	БАГЦ 58. БӨӨРНИЙ МЭС ЗАСАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
60	БАГЦ 59. МЭС ЗАСЛЫН НЭГ УДААГИЙН ХЭРЭГСЭЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
61	БАГЦ 60. ЭРҮҮ НҮҮРНИЙ МЭС ЗАСАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
62	БАГЦ 61. УХАРХАЙН ХАНА НӨХӨН СЭРГЭЭХ МЭС ЗАСАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25	

					/Эмнэлгийн хэрэгцээг хангана/ 2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
63	БАГЦ 62. УЯН ДУРАНГИЙН ХЭРЭГСЭЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
64	БАГЦ 63. ТАРХИНЫ МЭС ЗАСАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
65	БАГЦ 64. НУРУУНЫ МЭС ЗАСАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
66	БАГЦ 65. ШӨРМӨС ХОЛБООСЫН ГЭМТЛИЙН МЭС ЗАСАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
67	БАГЦ 66 ДЭЭД МӨЧНИЙ ЯСНЫ ХУГАРЛЫН МЭС ЗАСАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
68	БАГЦ 67. ДООД МӨЧНИЙ ХУГАРАЛ		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
69	БАГЦ 68. ТОМ ҮЕНИЙ ГЭМТЭЛ, ЭМГЭГИЙН МЭС ЗАСАЛ (ӨВДӨГ ҮЕНИЙ ХЭРЭГСЭЛ)		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	
70	БАГЦ 69. ТОМ ҮЕНИЙ ГЭМТЭЛ, ЭМГЭГИЙН МЭС ЗАСАЛ (ТҮНХНИЙ ҮЕНИЙ ХЭРЭГСЭЛ)		ш, фл, уп	ТТАХНЭ-ийн Эмийн нөөцийн өрөө	2022.03.01-ээс 2022.12.25 /Эмнэлгийн хэрэгцээг хангана/	

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 35.1.6-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь: **[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих]**

Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (барааны нийлүүлэлт хийх хамгийн эхний өдрөөс хойш нийлүүлэлт хийвэл зохих хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) нийлүүлэгдсэн байх шаардлагатай. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанаас өмнө нийлүүлэх санал ирүүлсэн тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд **[хувь бичих]**–иар тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

Барааг хуваарьт зааснаас **[тоо бичих]**-аас илүү **[“сар”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих]** хоцроож хүргэхийг санал болгосон тендерээс татгалзана. Харин ТӨХ-д тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон бараа нийлүүлэлтийн хуваариас хойш нийлүүлэхээр санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

2. Тендерт санал болгосон барааны урсгал зардал, үйл ажиллагааны баталгаа болон үр ашигтай байдал: **[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих]**

Хэрэв “ашиглах” бол тендерт санал болгосон барааны **[тоо бичих]** **[“сар”, “өдөр”, “жил” гэдэг үгнээс сонгож бичих]** хугацаанд шаардагдах урсгал зардлын хэмжээг тооцоолж ашиглалтын нийт хугацаанд шаардагдах нэмэлт зардлын дүнг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлнэ.

Мөн тендерийн дагуу санал болгосон барааны үр ашгийн байдлыг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлж болно.

3. Тендерт санал болгосон барааны борлуулалтын дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: **[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]**

Хэрэв “ашиглах” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлнэ.

4. Тендерийн дагуу санал болгож байгаа барааны гол эд анги, зайлшгүй шаардлагатай сэлбэг хэрэгсэл болон үйлчилгээний зардал: **[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих]**

Ашиглалтын эхн ий хугацааны дотор шаардагдаж болох гол эд анги, бүрдэл хэсэг болон сэлбэг хэрэгслийн нэр төрөл, тоо хэмжээний жагсаалтыг барааны жагсаалтад оруулсан байна. Ингэхдээ гол эд анги бүрдэл хэсэг болон сэлбэг хэрэгслийн үнийг тендерийн үнээс тусад нь ирүүлэх ёстой. Тендер бүрийн үнийн саналд дурдсан нэгж үнэд тулгуурлан дээрх жагсаалтад орсон эд зүйлсийн нийт үнийг тендерийн үнэ дээр үнэлгээний зорилгоор хийсвэрээр нэмж үнэлнэ.

Эсхүл

Барааны өндөр хэрэглээний ба өндөр үнэ цэнэ бүхий эд анги болон сэлбэг хэрэгслийн жагсаалтыг үйл ажиллагааны эхний үе шатанд хэрэглэгдэх тоо хэмжээний хамт бэлтгэнэ. Тендерийг үнэлэх зорилгоор эдгээр хэрэглэгдэхүүн болон тэдгээрийн тоо хэмжээнд харгалзах нийт үнийг тооцохдоо тендерт оролцогчийн ирүүлсэн сэлбэг хэрэгслийн нэгжийн үнийг тендерийн үнэ дээр нэмнэ.

5. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах чанар ба үнэлгээний арга (Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтаас бусад тендер шалгаруулалтад энэхүү үнэлгээний зааврыг тендерийн баримт бичгээс хасна)

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үед хамгийн бага харьцуулах үнэ (P_{min})-тэй тендерт 70 оноо (S_{max}) өгч, бусад тендерт оролцогчийн харьцуулах үнэ (P_x)-д харгалзах оноог дараах томъёогоор бодно.

$$S_x = \frac{P_{min}}{P_x} \cdot S_{max}$$

P_{min} – Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерт оролцогчийн үнэ

P_x – Тухайн тендерт оролцогчийн үнэ

S_x – Тухайн тендерт оролцогчийн оноо

S_{max} – Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерт оролцогчийн оноо

2. Чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

- 2.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын урьдчилан баталгаажуулалтад орсон бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо.

- 2.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй бол (SRA):

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо.

- 2.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь чөлөөт худалдааны гэрчилгээтэй бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

50 ≤ 60% - 1 оноо;
60 ≤ 70% - 2 оноо;
70 ≤ 80 % - 3 оноо;
80 ≤ 90 % - 4 оноо;
90 ≤ 100% - 5 оноо.

2.4. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Англи, Америк, Европын фармакопейн шаардлага хангасан нотлох баримт ирүүлсэн бол:

Тухайн багцын:
0 ≤ 50% - 0 оноо;
50 ≤ 60% - 1 оноо;
60 ≤ 70% - 2 оноо;
70 ≤ 80 % - 3 оноо;
80 ≤ 90 % - 4 оноо;
90 ≤ 100% - 5 оноо.

2.5. Эм, эмнэлгийн хэрэгслийг тендерт оролцогч үйлдвэрлэдэг бол:

Тухайн багцын:
0 ≤ 50% - 0 оноо;
50 ≤ 60% - 1 оноо;
60 ≤ 70% - 2 оноо;
70 ≤ 80 % - 3 оноо;
80 ≤ 90 % - 4 оноо;
90 ≤ 100% - 5 оноо.

2.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд тендерт оролцогч импортлодог бол:

Тухайн багцын:
0 ≤ 50% - 0 оноо;
50 ≤ 60% - 1 оноо;
60 ≤ 70% - 2 оноо;
70 ≤ 80 % - 3 оноо;
80 ≤ 90 % - 4 оноо;
90 ≤ 100% - 5 оноо.

3. Чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноог дээрх аргачлалын дагуу тооцох ба харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо бүхий тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

$$B_x = Q_x + S_x$$

B_x – Тухайн тендерт оролцогчийн чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноо

Q_x – Тухайн тендерт оролцогчийн чанарын үнэлгээний оноо

6. Тусгайлсан нэмэлт шалгуур

Хуулийн 28.4 дэх хэсэгт заасныг үндэслэн энэхүү тендерийн үнэлгээнд ашиглах нэмэлт шалгуур үзүүлэлт болон түүний аргачлалыг энэ хэсэгт оруулж болно.

[Тухайлбал, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа нийлүүлэх тендерийн харьцуулах үнийг дараах байдлаар тодорхойлно.

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1	Тендер илгээх маягт	1
Маягт 2	Барааны үнийн задаргаа	2
Маягт 3	Тендерийн баталгаа (банкны)	4
Маягт 4	Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)	5
Маягт 5	Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл	7
Маягт 6	Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл	7
Маягт 7	Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл	8

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[тендерт оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **[“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].**
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.²
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

² Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

Маягт 2 Барааны үнийн задаргаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс ³	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ⁴
1										<i>Тийм/Үгүй</i>
2										
...										
Тендерийн нийт үнэ										

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг, байгууллагын
тамга, тэмдэг]:***

³ ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

⁴ Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3 Тендерийн баталгаа (банкны)

Баталгаа хүлээн авагч: **[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[тендерийн баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]**

1. Баталгаа гаргагч нь **[тендерт оролцогчийн нэр]** (цаашид “тендерт оролцогч” гэх)-аас **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад оролцож тендер (цаашид “тендер” гэх) хүргүүлэхтэй холбогдуулан баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**-ийн⁵ төлбөрийн үүрэг хүлээх баталгаа гаргаж байна.
2. Энэхүү баталгааны дагуу төлбөр төлөх үүрэг дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:
 - 2.1. Тендер нээсний дараа, тендерийн хүчинтэй байх хугацаа (сунгасан хугацааг оролцуулан цаашид “Тендер хүчинтэй байх хугацаа” гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсаныг бичгээр мэдэгдсэн;
 - 2.2. Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх авсан үед тендерийн баримт бичигт заасны дагуу:
 - 2.2.1. ТШЗ-ны 41 дүгээр зүйлд заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй;
 - 2.2.2. гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
 - 2.2.3. тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
 - 2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
3. Дээр тодорхойлсон аль нэг нөхцөл үүссэнийг дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд баталгаа гаргагч төлбөрийг тус мэдэгдэлд заасан Монгол Улсын Сангийн яамны дансанд шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас төлөх шаардлагын хэмжээ нь 1-д заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.
4. Энэхүү баталгаа Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Баталгаа гаргагч энэ хугацаанаас өмнө гэрээ байгуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд баталгааг хугацаанаас өмнө хүчингүй болгож болно.
5. Энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг баталгааны хүчинтэй хугацаанд багтааж баталгаа гаргагчид мэдэгдэнэ.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосонтой холбоотой хариуцлагыг баталгаа гаргагч хүлээнэ.

[Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол тендерийн баталгааны дагуу хүргүүлэх шаардлагыг баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага, бусад этгээдийг заана уу.]

[Банкны эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]

⁵ Энэ дүн нь ТШЗ-ны 23.1-д заасантай ижил байна.

Маягт 4 Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)

Баталгаа хүлээн авагч: *[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]*

Огноо: *[баталгаа гаргасан огноог бичих]*

Дугаар: *[тендерийн баталгааны дугаар бичих]*

Баталгаа гаргагч: *[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]*

